

УДК 355.48

DOI: 10.22162/2587-6503-2021-2-18-19-41

**1921 оны хувьсгалын үед монголд байсан
халимагуудын нэр, тоог тодруулах нь
(= Уточнение имен и численности калмыков,
проживавших в Монголии во время революции
1921 года)**

*Наранжаргал Норовсамбуу*¹

¹ Центр по изучению языка, истории и культуры ойратов «Тод номын гэрэл» (8, район Сухбаатар, ул. Бага тойруу, 210646 Улан-Батор, Монголия)

научный сотрудник

ORCID: 0000-0001-5788-4618. E-mail: mr.naranjargal@mail.ru

© КалмНЦ РАН, 2021

© Норовсамбуу Наранжаргал, 2021

Аннотация. *Введение.* Активные связи между Монголией и Калмыкией осуществлялись в 1920-х гг. В 1921 г. в Монголию прибыли калмыки, которые принимали участие в событиях монгольской революции. До сих пор не было никаких сомнений в том, сколько калмыков участвовало в событиях тех лет в Монголии. Известны сведения о 130 калмыках, большинство из которых находились в Монгольской народной армии и являлись также переводчиками. *Цель статьи* — дать уточненные сведения об участии калмыков в монгольской революции 1921 г. на основе анализа новых архивных данных. *Результаты.* Представлены новые данные о калмыках, прибывших в Монголию в 1921 г. Уточнены количественные данные, сделан вывод, что всего в монгольских событиях в начале 1920-х гг. принимали участие 136 представителей калмыцкого народа.

Ключевые слова: Монголия, Калмыкия, 1920-е гг., монгольская революция

Для цитирования: Наранжаргал Н. 1921 оны хувьсгалын үед монголд байсан халимагуудын нэр, тоог тодруулах нь (= Уточнение имен и численности калмыков, проживавших в Монголии во время революции

1921 года) // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2021. № 2. С. 19–41. DOI: 10.22162/2587-6503-2021-2-18-19-41

UDC 355.48

Ethnic Kalmyks That Lived in Mongolia during the Revolution of 1921: Names and Numbers Specified

*Naranjargal Norovsambuu*¹

¹ Tod Nomyn Gerel Center for the Study of Oirat Language, History and Culture (8, Baga Toiruu St, Sükhbaatar District, 210646 Ulaanbaatar, Mongolia)
Research Associate
ORCID: 0000-0001-5788-4618. E-mail: mr.naranjargal@mail.ru

© KalmSC RAS, 2021

© Norovsambuu Naranjargal, 2021

Abstract. *Introduction.* The contacts between Mongolia and Kalmykia were intensive enough in the 1920s. In 1921, a group of Kalmyks arrived in Mongolia to further participate in the revolutionary events. So far there have been no essential doubts as for numbers of ethnic Kalmyks to have been involved into the revolutionary movement. There is available data on 130 Kalmyks the bulk of whom were serving in the Mongolian People's Army and also functioned as translators. *Goals.* The article aims at analyzing newly discovered archival materials to specify data on the participation of Kalmyks in the Mongolian Revolution of 1921. *Results.* The paper introduces new data on Kalmyks that arrived in Mongolia in 1921, clarifies their numbers, and concludes the Mongolian events of the early 1920s were attended by a total of 136 ethnic Kalmyks.

Keywords: Mongolia, Kalmykia, 1920s, Mongolian Revolution

For citation: Norovsambuu Naranjargal. Ethnic Kalmyks That Lived in Mongolia during the Revolution of 1921: Names and Numbers Specified. *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS.* 2021. No. 2. Pp. 19–41. (In Russ.). DOI: 10.22162/2587-6503-2021-2-18-19-41

Товчлол

1921 оны Монголын хувьсгалд багагүй халимагууд оролцсон юм. Энэхүү үйл явдалтай холбоотойгоор монголд албан ажлаар, цэргийн албан сургагчаар ажиллахаар, монгол улсаар дамжин бусад улсад тусгай үүрэг гүйцэтгэхээр, ар гэрээ дагах, амьдралын шаардлагаар суурьших зэрэг шалтгаанаар 136 халимаг хүн алба хааж, ажиллаж амьдарч байжээ. Тэдгээрээс 130 хүний нь нэр тодорхой байна.

Халимагууд Хаант Оросын бүрэлдэхүүнд орсноос хойш ах дүү монголчуудтайгаа харилцахыг чухалчилж байсан ч тэр бүр санаснаар нь болохгүй байлаа. Монгол болон Халимагуудын хоорондын харилцаа идэвхэжсэн үеүдийн нэг бол 1920-иод он байлаа.

Энэхүү судалгаандаа 1921 оны хувьсгалын үед Монголд ажиллаж байсан халимагуудын нэрсийг тодруулахыг зорьсон болно. Өнөөдрийг хүртэл тухайн үед Монголд хичнээн халимагууд байсан нь тодорхойгүй бөгөөд эдгээр халимагуудын ихэнх нь монголын ардын журамт цэрэгт алба хааж, монголд байсан зөвлөлтийн цэргийн ангиудад орчуулагч-аар ажиллаж, монголоор дамжин бусад улсуудад тусгай даалгавар гүйцэтгэж байсан зэрэг нь тэднийг тоог тодорхой гаргаж нэрсийг нь тодруулахад илүү төвөгтэй болгож байна. Иймээс Халимагийн үндэсний төв архив болон Монголын үндэсний төв архив дахь баримт материал, Монголд алба хааж байсан халимагуудын дурдатгал, дурсамж зэрэгт тулгуурлан тэдгээрийг тодруулахыг оролдсон болно. Энэ талаар судлаачид өнөө хүртэл дорвитой судалгаа хийгээгүй бөгөөд миний бие магистрын зэрэг горилсон судалгааны бүтээлдээ тэдний тоог 114 гэж гаргасан боловч сүүлийн үеийн судалгаагаар энэ тоо нэмэгдсээр байна. 1921 оны хувьсгалын үед Монголд ажиллаж байсан халимагуудын нэрийг тодруулснаар тухайн үеийн зарим үйл явдлыг ойлгоход дөхөм болох юм. Энэ үед Монголд ажиллаж байсан халимагуудыг дараах байдлаар ангилан үзэж болохоор байна. Үүнд:

— Цэргийн алба хааж байсан халимагууд

— Монголд албан ажлаар ирж байсан халимагууд

— Монголоор дамжин тусгай үүрэг гүйцэтгэж байсан халима-

гууд

— Монголд алба хааж байсан Халимагуудын ар гэр

— Бусад хэмээн ангилан үзэж болохоор байна.

Цэргийн алба хааж байсан халимагууд: Зөвлөлт Оросын зүгээс Ази тивд социалист хувьсгалыг экспортлох бодлогодоо Зөвлөлт Халимагуудыг ашиглах бодлого баримталж байсан нь Москвад очсон Ардын намын төлөөлөгчид цэргийн зөвлөх, сургагчаар туслах хүсэлт тавьсантай давхацсанаар улаан армид алба хааж байсан Халимагуудыг Монголд үүрэг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэжээ. Ингэснээр Монголд алба хаах халимаг дайчдыг сонгон бэлтгэх ажлыг Халимагт 3 удаа зохион байгуулж, бэлэн болсон дайчдыг хоёр хэсэг болгон илгээсэн байна.

Халимаг цэргийн сургагч нарын эхний хэсэг: Москвад Улаан армийн Халимаг морин цэргийн ангийн зохион байгуулагч, улс төрийн удирдагчаар ажиллаж байсан Х. Б. Кануков 1921 оны нэгдүгээр сарын сүүлээр Халимагийн 108-р хорооны дарга В. А. Хомутниковт өөрийн дарга нарын дотроос 16–20 халимаг дарга нарыг шилж сонгон авч Москвад ирэхийг даалгасан цахилгаан илгээжээ. В. А. Хомутников уг цахилгааныг хүлээн аваад «өөрийн хорооны сумангийн дарга Андрей Дрючков, Цаган Манж Очиров, сумангийн орлогч Алексей Ханхалжинов, хорооны адьудант Тимофей Шивидов, түүний туслах Борис Юнзуков, салааны дарга Коклда Лиджиев, Наран Манжиков, Дорж Мартышкин, Дорж Дарминов, Боля Шургучинов, Бадма Манжиков, Доржа Эрднеевич Шапшуков, хорооны зэвсгийн дарга Петр Иванов, ханган бэлтгэхийн орлогч, хорооны тугчин Керядык Сафонов, төмөр замын Сальск өртөөнөөс Николай Кануков, Илья Теврюков, Иван Манджиков, Зул Корняев» нарын 18 бага даргыг авч Москвад очжээ [Оглаев 1977: 33–34].

Эдгээр сургагч нарын ихэнх нь намын гишүүн бөгөөд Кануков Харти Бадиевич 1918 онд, Хомутников Василий Алексеевич 1917 онд, Шивидов Тимофей Бадиевич, Иванов Петр Борисович, Дрючков Андрей Дмитриевич нар 1919 онд ОК(б)Намын гишүүнээр элссэн туршлагатай хувьсгалчид байсан бол Манжиков Дорж Иванович, Шапшуков Георгий Андреевич, Лиджиев Коклда Иванович, Манжиков Некия Ониневич, Сафонов Керядык

Апинович, Шургучинов Боля Шургучинович, Ханхалжинов Алексей Алексейвич нар намын орлогч гишүүд байв. Мөн Манджиев Наран Тонхеевич, Очиров Цагаан Манджи, Юнзуков Борис нар 1921 онд тус тус ОК(б)Н-ын гишүүнээр элссэн бол Теврюков Илья Абрамович, Мартышкин Доржа Манжикович нар хожим 1923 онд намын гишүүнээр элссэн улс төрийн хувьд итгэл хүлээлгэж болох намын боловсон хүчин байлаа. Намын гишүүн биш ганц хүн байсан нь Кануков Николай Бадиевич боловч тэрээр тус бүлгийн ахлагч Х. Б. Кануковын дүү байсан юм. Багийн бүрэлдэхүүнийг насны хувьд авч үзвэл хамгийн залуу нь Манджиев Наран Тонхеевич 21 настай, хамгийн ахмад настай нь Мартышкин Доржа Манжикович бөгөөд 40 настай байв. Эдгээр 18 хүнээс 11 нь 21–29 насныхан байсан бол үлдсэн 7 нь 30–40 насныхан байжээ. Эндээс үзэхэд, эдгээр дайчид насны хувьд идэр залуу ч иргэний дайнд оролцож, хороо, суман удирдаж байсан дайн тулаан болон цэрэг зохион байгуулах дадлага, туршлагатай, намын гишүүн болж улс төрийн үзэл бодол нь төлөвшсөн цэрэг, улс төрийн чадварлаг мэргэжилтнүүд байлаа.

Халимаг сургагчдыг ийнхүү Монголд илгээсэн явдал нь Автономит Халимагийн засгийн газрын шийдвэр бус Улаан армийн дээд удирдлагын шийдвэр байлаа. Харин эдгээр сургагч нарыг сайн дурын үндсэн дээр сонгож авсан бөгөөд хэдийгээр даалгавар нууц байсан хэдий ч дээрх сургагчид өөрсдийг нь Монгол руу явуулна гэдгийг битүүхэндээ мэдэж байсан гэдгээ дурсамждаа өгүүлснээс үзвэл тэд Зөвлөлт Оросын зүгээс Монголд явуулсан даалгаврыг гүйцэтгэхээр сайн дураар Монголд иржээ.

Эдгээр сургагч нарыг Тонхой өртөөнд байхад нь Монголд ажиллах даалгавартай нь холбоотойгоор бүгдэд нь нууц нэр өгсөн тухай мэдээлэл Халимагийн үндэсний архивын сан хөмрөгт байдаг. Энэ нь:

- 1) Кануков Харти Бадиевич — Вокунаев Итрах;
- 2) Хомутников Василий Алексеевич — Кекеев Сангаджи;
- 3) Шивидов Тимофей Бадиевич — Гюмбеев Коко;
- 4) Иванов Петр Борисович — Лундуков Шагдыр;
- 5) Дрючков Андрей Дмитриевич — Бен-Али;

- 6) Левин Михаил Абрамович — Норво;
- 7) Ханхалжинов Алексей Алексеевич — Турхунаев Ханду;
- 8) Теврюков Илья Абрамович — Кюлценгеев Цецен;
- 9) Мартышкин Доржа Манжикович — Нутугаев Монгол;
- 10) Кануков Николай Бадиевич — Налхаев Артур;
- 11) Манжиков Алексей Иванович — Толоктаев Болзок;
- 12) Шапшуков Доржа Эрдниевич — Дорджиев Цебек;
- 13) Сафонов Керядык Апинович — Боглаев Джама;
- 14) Шургучинов Боля Шургучинович — Нуртаев Кюмен;
- 15) Лиджиев Коклда Иванович — Мустабеков Бембя;
- 16) Манжиков Бадьма Онинович — Толвуртаев Кюмен;
- 17) Манджиев Наран Тонхсевич — Бимбаев Мацак Тонхсевич;
- 18) Очиров Цаган-Манджи — Хамбаев Самбу;
- 19) Юнзуков Борис — Номинханов Церен-Дорджи [НА РК. Р-137.Оп. 1.Д. 8. Л. 30] гэсэн нэрсийг өгчээ.

Эдгээр сургагч нар Монголд байх хугацаандаа бүгд дээрх нэрийг хэрэглэж байсан бөгөөд зарим нь бүр дахин нэмж өөр нэр хэрэглэх тохиолдол байв. Тухайлбал, Х. Б. Кануков л гэхэд Ухонаев [Д. Сүхбаатарын тухай баримт 1960: 176], Итрах Вакунаев, торгууд Балданцэрэн [МУУТА. ТБА. Х. 1. Д. 1. Хн. 81] зэрэг нэрийг хэрэглэж байжээ. Харин Манджиев Наран Тонхсевич, Юнзуков Борис нар Бимбаев Мацак Тонхсевич, Номинханов Церен-Дорджи гэх энэ нууц нэрээрээ насан эцэслэтлээ амьдарсан юм.

Эдгээр сургагчдын яг хэдний өдөр монголд ирсэн нь тодорхойгүй бөгөөд 1921 оны 5 дугаар сарын сүүл, 6 дугаар сарын эхээр ирсэн гэсэн тоймлосон хугацаа байдаг. Энэ тухай архивын баримтад байхгүй, харин бусад эх сурвалжийг ашиглан тодруулбал, тус бүлэгт багтан ирсэн сургагчдын ихэнх нь тавдугаар сарын сүүл, зургаадугаар сарын эхээр ирсэн хэмээн дурдатгалдаа өгүүлсэн байдаг бол Г. А. Шапшуков «... Монгол улсын умард хилийн Маймаа (одоогийн Алтанбулаг) хэмээх жижиг хотод 1921 оны 6 дугаар сарын 3-ний өдрийн үдээс хойш хүрэлцэн ирлээ» [Шапшуков 1975: 105] гэсэн бол Ц.-Д. Номинханов «... Бид Хиагтын усан буудлаас хос морьтой улаа хөсөг хөлслөн авч 1921 оны 6 дугаар сарын 4-ний орой Монголын хилийн эхний хот Маймаа

хотод хүрсэн...» [Номинханов 1977: 68] зэргээр ирсэн өдрөө тодорхой заасан байдаг. Хожмын Тамбовын морин цэргийн сургуульд ажиллаж байсан Г. А. Шапшуков, Халимагийн анхны шинжлэх ухааны доктор, хэл шинжлэлийн нэрт эрдэмтэн болсон Ц-Д. Номинханов нарын сэхээтнүүдийн дурдатгалдаа өгүүлсэн цаг хугацааг бодитой хэмээн тус бүлгийг Алтанбулагт 1921 оны 6 дугаар сарын 3-аас 4-ний хооронд ирсэн гэж үзэж байна.

Х. Б. Кануковын ахалж ирсэн энэ бүлгийн бага дарга нарын нэр болон тоог нарийвчлан авч үзвэл зөрөөтэй байна. Х. Б. Кануковын тушаалаар В. А. Хомутников өөрийн хорооны 14 бага дарга дээр төмөр замын Сальск өртөөнөөс нэмж 4 бага даргыг авч нийт 18 бага даргатай хамт 19 хүн Москвад очсон бөгөөд тэдэн дээр Х. Б. Кануков нэмэгдээд 20 хүн болж байна. Харин Тонхой өртөөн дээр Монгол руу явж байсан 19 сургагчид нууц нэр өгөхөд анх Халимагаас В. А. Хомутниковын авч гарсан Зул Корнаев, Дорж Дарминов нарын нэр байхгүй бөгөөд харин Левин Михаил Абрамович нэмэгдэн Норво гэх нууц нэр авсан боловч Монголд очсон эхний сурагч нарын дотор түүний нэр алга байна.

Тухайн үед халимаг сургагчид ганц нэгээрээ ирэх тохиолдол байсан бөгөөд анх В. А. Хомутниковын бүлэгт багтан Халимагаас гарсан Дорж Дарминовын нэр Монголд ирсэн хоёр удаагийн сургагчдын бүртгэлд байхгүй ч 1922 онд Жаа ламыг устгах тусгай даалгавар гүйцэтгэж яваад баригдан буудуулсан байдаг. Эндээс үзвэл 1921 оны хавар Монголд тусгай даалгавар гүйцэтгэхээр ирсэн халимаг сургагч нарын бүлэг Х. Б. Кануков, В. А. Хомутников, А. Д. Дрючков, Ц. М. Очиров, А. А. Ханхалжинов, Т. Б. Шивидов, Б. Юнзуков, К. И. Лиджиев, Н. Т. Манжиков, Д. А. Мартышкин, Б. Ш. Шургучинов, Н.(Б). О. Манжиков, Г. А. (Д. Э.) Шапшуков, П. Б. Иванов, К. А. Сафонов, Н. Б. Кануков, И. А. Теврюков, Д. И. Манджиков нарын 18 хүн багтаж байжээ.

Эдгээр халимаг сургагчид Ардын журамт цэрэг болон Зөвлөлтийн аялан байлдах корпусын бүрэлдэхүүнд орж 1921 оны 7 дугаар сарын 8-нд Нийслэл хүрээнд ирж, 1921 оны 7 дугаар сарын 10-нд Ардын Засгийн Газрыг тунхаглах, монгол орныг гамин, бароны үлдэгдлээс чөлөөлөх үйл хэрэгт багагүй үүрэгтэй оролцсон юм.

Халимаг цэргийн сургагч нарын хоёр дахь хэсэг:

Ардын засгийн газрыг байгуулсны дараа Монгол орны нутаг дэвсгэрээр бутран сарниад байсан гамин болон цагаан цэргийн үлдэгдлийг Монголын нутаг дэвсгэрээс хөөн гаргаснаар хувьсгалын үйл хэргийг бүрэн ялалтад хүргэх байлаа. Ардын засгийн газар нөхцөл байдлыг харгалзан үзээд аялан байлдах корпусын цэргүүдийг цагаантны үлдэгдлийг дуусгах хүртэл Монгол нутагт байлгаж, АЖЦ-т туслуулах хүсэлтийг Зөвлөлтийн талд 1921 оны 7-р сарын 12-нд тависан байна [Внешняя политика СССР 1944: 149]. Уг хүсэлтийн дагуу 1921 оны 8 дугаар сарын 10-нд Г. В. Чичерин «Одоогийн ноцтой байдал нийтийн дайсныг хамжин устгах тус хоёр улсын ашиг сонирхолыг хамжин үзэх нь зүйтэй ... Монгол улсын ардын хувьсгалт засгийн газрын хүсэлтийг бүрэн дүүрэн хүлээн авч байна» гэсэн хариу ирүүлсэн байдаг [Советско-монгольские отношения 1966: 8–9].

Монголд орж ирээд байсан Зөвлөлтийн цэргүүдийг хэсэг хугацаанд Монголд үлдээх шийдвэр хоёр улсын засгийн газрын хороонд ийнхүү шийдэгдэж байх үед Халимагт Монгол руу илгээх хоёр дахь ээлжийн бага дарга нарыг бүрдүүлэн бэлэн болгожээ. Энэхүү Халимаг бага дарга нарын хоёр дахь бүлгийг Зөвлөлтийн засгийн газарт улаан армийн аялан байлдах корпусын цэргийг Монголд түр хугацаанд үлдээх Монголын засгийн газрын «... хүсэлт ирэхээс өмнө хувьсгалт цэргийн зөвлөлд (Халимагийн хувьсгалт цэргийн зөвлөл болов уу. — Н. Н.) Монголын ардын хувьсгалт армийн хүсэлтээр <...> явуулахаар шийдсэн» гэж судлаач О. Ю. Оглаев үзсэн байдаг. Хэрэв энэ үнэн бол уг хүсэлтийг Д. Сүхбаатарын нарын АЖЦ-ийн удирдагчдын зүгээс урьд ирээд байсан Х. Б. Кануков нараар уламжлуулан тавьсан байж болох юм. Д. Сүхбаатар АЖЦ-т алба хааж байсан халимаг сургагчдыг орос болон монгол хэл мэддэг хүмүүс маш хэрэгтэй хэмээн өндрөөр үнэлдэг байсан билээ. Халимагийн цэргийн комиссариатас Калмыцкий Базар (Халимагийн зээл) сууринд байрлаж байсан халимаг морин цэргийн бэлтгэл дивизионы цэрэг, дарга нараас 52 залуу дайчдыг сонгон авч, Ижилийн тэртээх цэргийн тойргийн штабын мэдэлд шилжүүлээд улмаар 1921 оны 8 дугаар сарын 18-нд Монташ Лиджиевээр удирдуулан Самар хот руу явуулжээ.

Эдгээр дайчдын ахлагч нь Лиджиев Монташ, салааны дарга нь Уланов Иван нар байсан бөгөөд тэдний бүрэлдэхүүнд *Ижилийн эрэг орчмын цэргийн комиссариатаас армид татагдсан Лиджиев Монташ, Уланов Иван, Бадукаев Бадма Халга, Босхомджиев Улюмджи, Ильянов Мучка, Морхадыков Бурдан, Мясненко Петр, Каменский Михаил нар; Яндыко Мочажын цэргийн комиссариатаас татагдсан Очиров Могу, Лиджи Гаряев Оджа, Болдырев Манджи, Бадмаев Лиджякя, Ванькаев Бембе, Дораев Мухта, Натыров Очир, Отхаев Тюрбе, Малзрыков Лиджи Гаря, Надбитов Тюлюмджи нар; Манычийн цэргийн комиссариатаас татагдсан Арашкжиев Саран, Цебеков Тануш, Баранов Эрэнцен, Савкинов Дорджи, Тутаев Будя, Мукебенов Александр, Миндеев Авлян, Каруев Окон, Лиджиев Муджа, Балтыков Сангаджи Гаря, Мукаев Ядош, Чавяев Анджа, Савгуров Манджи, Душаев Адык, Микалаев Очир Гаря, Гучинов Ноха, Шопкаев Сангаджи, Мугульджиков Василий, Шалбуров Артюш, Очиров Ханцан, Каблунов Эренджен, Мамонтов Дмитрий, Трешев Николай, Шопкаев Сангаджи, Захаров Петр, Босаев Сулейман, Аристаев Ильяс, Перепелицын Дмитрий, Шпаков Петр, Таранин Павел, Самойленко Павел, Хворошин Иван, Резвушкин Яков, Бориснев Григорий* [НА РК. Ф. Р-3. Оп. 2. Д. 375. Л. 4] нар 52 хүнээс бүрдэж байлаа. Бие бүрэлдэхүүнийг насных нь хувьд авч үзвэл, 1895 онд төрсөн 26 настай байлдагч 1, 1896 онд төрсөн 25 настай байлдагч 1, 1897 онд төрсөн 24 настай байлдагч 3, 1898 онд төрсөн 23 настай байлдагч 24, 1899 онд төрсөн 22 настай байлдагч 3, 1900 онд төрсөн 21 настай байлдагч 8, 1901 онд төрсөн 20 настай байлдагч 9, 1902 онд төрсөн 19 настай байлдагч 1 байв. Хамгийн залуу нь Ижилийн эрэг орчмын суурины цэргийн комиссариатаас ирсэн 19 настай байлдагч Мясненко Петр байсан бол ахмад нь мөн тэндээс ирсэн салааны дарга 29 настай Уланов Иван байжээ. Энэ бол Монгол улс руу илгээхээр Халимаг цэрэг дарга нараас сонгон авсан 2 дахь бүлэг байлаа.

Эдгээр дайчид дээр нэмэн Халимаг мужийн цэргийн комиссариатын 1921 оны 9 дүгээр сарын 27-ний өдрийн шийдвэрээр Халимагийн морин цэргийн бэлтгэл дивизионы дарга, цэргүүдээс Монгол улсад онцгой даалгавар гүйцэтгэх 3 дахь бүлгийн 44 цэр-

гийг сонгон авч Ижилийн тэртээх цэргийн тойргийн мэдэлд шилжүүлсэн бөгөөд тэднийг Максим Шапшуковоор удирдуулан Самар хотод 1921.8.18 илгээсэн хоёр дахь бүлгийн хойноос явуулжээ.

Уг бүлгийг Шапшуков Максим ахлаж байсан ба Джамбаев Павел, Саматов Ишимгази нар уг бүлгийн орлогчид байв. *Шапшуков Максим, Джамбаев Павел, Скрынников Тимофей, Кочумаров Кирилл, Панасенко Иван, Шахов Егор, Панченко Иван, Брагин Кузьма, Хулхачиев Дола, Хайсоков Гавриил, Дангринов Василий, Давыдов Яков, Андратов Петр, Землянский Василий нар Бага Дөрвөдийн цэргийн комиссариатаас; Саматов Ишимгази, Курсинов Эрэнджес, Букаев Эвя, Мучкаев Кота, Ангаев Баасан, Эринеv Эльтош нар Эркетений цэргийн комиссариатаас; Эрдэнэ Гаряев Шургун, Сарангов Кензя, Бултаджиев Манджи, Шургучиев Очир-Ара, Шаршиев Ура-Гали, Наранаев Эльдя нар Ижилийн эрэг орчмын суурингийн цэргийн комиссариатаас; Эрдниеv Долан, Бадмаев Сангаджи, Доляев Му, Багляев Чимид, Базыров Москва, Манджиев Кукет, Очиров Басанг, Батанасунов Халга, Гаряев Доля, Уланов Санька, Бульков Саранг, Мухараев Церен нар Икицохуро-Хара-хусовын цэргийн комиссариатаас; Харагуюров Эльдя-Гаря, Кекеев Боролда нар Яндыко-Мочажьийн цэргийн комиссариатаас; Трашев Алексей Манычийн цэргийн комиссариатаас Зикманов Сангадуш, Сангадушев Сергя, Джиринтеев Кюста нар Приволжскийн цэргийн комиссариатаас тус тус армид татагдсан хүмүүс байв [НА РК. Ф. Р-3. Оп. 2. Д. 375. Л. 3]*. Эдгээр дайчдыг насных нь хувьд авч үзэхэд, 1893 онд төрсөн 28 настай байлдагч 3, 1894 онд төрсөн 27 настай байлдагч 1, 1895 онд 26 настай байлдагч 1, 1896 онд төрсөн 25 настай байлдагч 17, 1897 онд төрсөн 24 настай байлдагч 6, 1898 онд төрсөн 23 настай байлдагч 2, 1899 онд төрсөн 22 настай байлдагч 5, 1900 онд төрсөн 21 настай байлдагч 1, 1901 онд төрсөн 20 настай байлдагч 6 байжээ. Эндээс харахад хамгийн ахмад нь 28 настай байхад хамгийн залуу нь 20 настай байжээ. Хоёр бүлэг нь Самар хотод нэгдэн Халимагийн суман болж бүрдээд, холбогдох бэлтгэл сургууль хийсний дараа Дорнод Сибирт байрлаж байсан V армийн командлалаас бүрэн зэвсэглэ-

лээд Улаан-Үдээр дамжин 1921 оны 12 сарын сүүлээр Нийслэл Хүрээнд чаргаар иржээ [Балтыков 1977: 121].

Нийслэл Хүрээнд Ардын засгийн газар байгуулагдсаны дараа АЖЦ-т алба хааж байсан халимаг сургагчид АЖЦ-ийн хороо сумангуудад үргэжлүүлэн сургагчаар ажиллаж байсан бөгөөд тэдний тоо цөөн байсан учраас бүхий л үйл хэрэгт оролцож байгаагүй тэднийг аль чухал, хүн хүч хэрэгтэй газруудад томилон ажилуулж байлаа.

Монголд цэргийн алба хааж байсан бусад халимагууд: Энэхүү Халимагаас ирсэн хоёр бүлгийн сургагч нарын албан ёсны нэрсийн бүртгэлд ороогүй Дорж Дарминов, Михаил Абрамович Левин нар Монголд ирж хувьсгалын үйл хэрэгт оролцож байсан бол Халимагаас Монгол явах сургагч нарын бүртгэлд нэр нь орсон ч Монголд ирсэн эсэх нь тодорхойгүй Зул Корнаев зэрэг хүмүүсийн тухай дээр өгүүлсэн билээ.

Эдгээр сургагчдаас гадна Монгол ардын журамт цэргийн бүрэлдэхүүнд алба хааж байсан Халимаг байж болох дараах хүмүүс байна. Үүнд:

1. *Никитин:* Баруун хязгаарыг цагаантны цэргээс чөлөөлөх цэргийн ажиллагаанд ЗОУ-ын Улаан цэргийн гүйцэтгэсэн үүрэг багагүй бөгөөд эдгээр цэргүүдийн дотор халимаг цэргүүд байсан тухай архивын баримт байхгүй ч Никитин, Широких-Полянский зэрэг халимаг байж болох хүмүүс байна. Монгол газар удтал суусан Центросоюзын албан хаагч Никитинийг Байкалов Хөшөө модноос орчуулагчаар авч гарсан бөгөөд авхаалж зоригийг нь нь үнэлэн удалгүй тавин монгол цэргийн даргаар томилсон байна [Даш 1967: 161]. Никитинийг цэргүүд нь шар Намсрай, Халимаг Намсрай, торгууд Намсрай зэргээр нэрлэж байсан ба судлаач Н. Батбаяр [Батбаяр 1972: 46] болон түүхч На. Сүхбаатар [Сүхбаатар 2000: 28], Л. Бат-Очир, С. Отгонжаргал [Бат-Очир, Отгонжаргал 1996: 46] нар бүтээлдээ: АТЗГ-ын төлөөлөгч Ч. Хасбаатар нар Дөрвөд далай хааны нутагт ирж Цэвээн гүн, Молом лам нартай хэлэлцээр хийх үед «... Сибирийн алдарт партизан Широких-Полянский, Зөвлөлтийн улаан цэргийн офицер шар Намсрай буюу халимаг Никитин, КИМ-ийн Нацов нар цуг байсан» гэж тэмдэглэсэн зэргээс түүнийг халимаг хүн байсан болов уу гэж үзэж байна.

2. *Церенов*: К. К. Байкаловын отрядын улс төрийн орлогч Широких-Полянский Сергей Юльевичыг мөн цэргүүд нь торгууд Церенов [Монгол ардын журамт 1982а: 72] хэмээн нэрлэдэг байсан юм. Түүний тухай Д. Лосол: «...баруун хойд хязгаарыг төвшитгөн товхинуулах хэрэгт хэнийг томилохыг хэлэлцэж төлөөлөгчид Дамбадорж, Баляский (Полянский (Цереновын өөр нэгэн нэр. Цереновын Орос нэр нь Широких-Полянский Сергей Юльевич), Хасбаатар, Өлзийханд нарыг томилж үнэмлэх заавар олгож явуулахаар тогтсон» [Монгол ардын журамт 1982б: 418], Ц. Аюушжав: «... Хасбаатар, тэгвэл чамайг цэрэгтээ элсүүлж авъя, чамайг торгууд Цереновын тавьтын Цагаан гэдэг даргын арванд өгье гэв» [Монгол ардын журамт 1982а: 72], З. Бямбиш: «... Халиунбулагт 100 гаруй цагаан цэрэг байна гэж мэдээ ирлээ. Хасбаатар Намсрайн захиргаан доор Цереновын салаанд надтай хамт Дамиран, Жалуан, Хөх, Цонгоо, Цэнгэг нарыг оруулж явуулав» [Монгол ардын журамт 1982а: 296] хэмээн дурдатгалдаа өгүүлсэн байдаг. Эндээс харахад Широких-Полянский Сергей Юльевичийг баруун хязгаарт ихэвчлэн Церенов, торгууд Церенов хэмээн нэрлэж дууддаг байжээ. Монголчууд Ижил мөрний халимагуудыг дийлэнх ястных нь нэрээр «торгуудууд» хэмээн нэрлэдэг байсан бөгөөд мөн Церенов гэх нэр нь Монгол угсаатан болох буриадуудаас илүү халимагуудын дунд ихээхэн өргөн дэлгэрсэн байдаг. Энэ бүхнээс үзэхэд Широких-Полянский Сергей нь баруун хязгаарт торгууд Церенов гэж нэрлэгдэж байсан Халимаг гаралтай хүн бололтой.

Эдгээр халимаг байж болох хүмүүсийн уг гарлын тухай мэдээ баримт Халимагаас олохгүй байгаа нь эдгээр хүмүүс нь Халимагаас хувьсгалын өмнө гарч явснаас болсон болов уу. Нөгөө талаар тэд ЗОУ-ын Засгийн газрын шууд удирдлага дор өөр шугамаар ирж, тусгай үүрэг гүйцэтгэж явсан ч байж болох талтай. Иймээс энэхүү асуудлыг цаашид нарийвчлан судлан тодруулах шаардлагатай.

3. *Бобров*: Ховд сайдын газар ажиллаж байсан Х. Б. Кануковын Д. Сүхбаатарт бичиж байсан захидлуудын агуулгаас харахад түүнтэй хамт бусад халимаг хүмүүс цөөхөн байсан бололтой. 1922 оны 7 сарын 25-ны өдрийн захидалдаа «... Бобровыг хүрэнээ

татан авсан учраас би бүх хэргээ ганцаар хөтлөх учиртай болж бас өдий төдий тус сайтай хүмүүсийг та минь хүрээнээ суулгасар надад туслалцаж чадах ганцхан Кюлценгеевоос өөр хүнгүй буй за» [МУУТА. ТБА.Х. 2. Д. 1.Хн. 171] гэснээс үзэхэд тэрхүү «өдий төдий тус сайтай хүмүүс» гэдэгт нь хамт алба хааж байсан Халимаг сургагчдаа хэлсэн болов уу. Тийм бол түүнтэй хамт бусад халимаг сургагчидаас нь Кюлценгеев буюу И. А. Теврюковоос бусадгчдыг нь явуулаагүй болох нь харагдаж байна. Харин өөрийнх нь ажилд тусалдаг гэх Бобровыг хүрээнд татан аваачсан тухай өгүүлсэнээс тэр ямар хүн байсан тухай баримт алга байна. Х. Б. Кануковтой ойрхон ажиллаж байсан тул халимаг хүн байсан болов уу гэж үзвэл Халимагаас ирсэн дайчдын бүртгэлд түүний нэр байхгүй байдаг.

4. *Сиволобов*: Албан ёсны бүртгэлд орохгүйгээр ирсэн халимагууд цөөнгүй байсан. Тухайлбал, мөнөөх захидлуудад нэр нь дурдагдаж байгаа Сиволобовын асуудал юм. Түүний тухай Х. Б. Кануковаас Д. Сүхбаатарт 5 сард бичсэн захидалдаа «эсгүүр сайн хийдэг, засварын газар ажиллах боломжтой <...> түүнийг энд хийгээд байх юмгүй болохоор би эндээс явуулчихлаа» [МУУТА. ТБА. Х. 2. Д. 1. Хн. 171] гэж бичсэн бол 1922 оны 7 сарын 25-нд Д. Сүхбаатарт бичсэн захидалдаа «...Сиволобовын тухай мэдүүлэх нь энэ хүн бол бид нар торгууд нарын тоонд оролцох бөгөөд хэрэв үнэхээр хулгай дээрэм хийвэл түүнийг бяцхан ч үл асрах бөгөөд би өөрөө мэдэх бол буугаар буудаж алах агсан гэх боловч бас өртөөний хүмүүстэй хэрэлдсэн учраас хардагдсан байж болох хэмээн санагданам. Юу ч бол тэндээ үнэхээр байцаагдаж шийтгэгдэх учиртай ажээ» [МУУТА. ТБА. Х. 2. Д. 1. Хн. 171] гэсэн байна. «... Энэ хүн бол бид нар торгууд нарын тоонд оролцох бөгөөд...» гэснээс үзэхэд Сиволобов нь торгууд буюу халимаг хүн байжээ. Гэвч Халимагаас ирэгсэдийн дотор нэр нь алга байна. Түүнийг Х. Б. Кануков Ховдод ирсэнийхээ дараа тэнд онцын шаардлагагүй гэж үзсэн тул Хүрээ рүү буцаасан байна. Тэрээр магадгүй буцаж явах замдаа өртөөний хүмүүстэй хэрэлдэж маргалдсан ба дараа нь тэдгээр өртөөний хүмүүс Сиволобовыг хулгай дээрмийн хэрэгт холбогдуулан гомдол гаргасанд Д. Сүхбаатар Халимаг сургагчдыг

хамаардагынх нь хувьд Х. Б. Кануковаас захидлаар энэ тухай нь асуусан бололтой. Уг асуудал хэрхэн шийтгэгдсэн тухай баримт материал одоогоор олдохгүй байна.

5. *Левин Михаил Абрамович*: Анх Х. Б. Кануковын даалгаснаар В. А. Хомутниковын бүрэлдэхүүнд орсон бөгөөд Танхо өртөөнөөс Норво гэх нууц нэр авсан боловч Монголд очсон эхний сурагч нарын дотор түүний нэр алга байна. 1923 оны 8 сард Монголд ажиллаж байсан Халимаг сургагчдын бүртгэлд түүнийг Тамсаг булагт алба хааж байсан гэж тэмдэглэсэн байдаг [НАРК. Ф. Р-137. Оп. 1. Д. 2. Л. 84-45]. Ц-Д. Номинханов түүнийг 1921 оны 12 сард ирсэн халимаг сургагчдын хоёрдугаар хэсэгт багтсан ирсэн гэдэг ч нэр нь тэдгээр сургагчдын бүртгэлд байдаггүй. 1921 оны хавар Танхой өртөөнөөс авсан Норво гэх нэр ч түүхэн баримтад таарахгүй байгаагаас үзвэл тэрээр 1921 оны 6 болон 12 сард Халимагаас ирсэн хоёр бүлгийн сургагчдаас тусдаа ирсэн бололтой.

6. *Лиджиняев Эрдэни*: Монгол улсад хэзээ ирсэн нь тодорхойгүй бөгөөд 1923 онд Тамсагбулагт байсан [НАРК. Ф.Р-137. Оп. 1. Д.2. Л. 84-45] бөгөөд харин 1924 онд Х. Б. Кануковын гаргасан «Монгол улсын Ховдын хязгаарт нүүн ирж тохинохыг хүсэх халимаг торгууд нарын нэрсийг тодорхойлон бичсэн хуудас» хэмээх баримтын 39 дугаарт «Лиджиев Эрдни Шагвуров, 25 настай, эхнэргүй, Иновийская станцад амьдардаг, газар хэмжигч мэргэжилтэй, пулёмотчин, намын гишүүн» [МУУТА. ТБА. Х. 1. Хн. 29] гэж тэмдэглэгдсэн байна. Эдгээрээс үзвэл тэрээр 1922 оны сүүл 1923 оны эхээр Монголд ирж, 1925 онд бусад халимагуудын хамт нутаг буцсан бололтой.

7. *Шангунцинов Василий*: Монголд хэзээ ирсэн нь тодорхойгүй бөгөөд Х. Б. Кануковын 1923 онд гаргасан тодорхойлолтоор Ховдод алба хааж байсан [НАРК. Ф. Р-137. Оп. 1. Д. 2. Л. 84-45] бол 1924 онд гаргасан тодорхойлолтын 55 дугаарт «Шангунцинов Василий 24 настай, эхнэртэй, Зундуков тосгоных, газар хэмжигч мэргэжилтэй, малчин, намын гишүүн биш» гэж тэмдэглэгдсэн [МУУТА. ТБА. Х. 1. Хн. 29] байдаг. Эндээс үзэхэд 1925 оны үед нутаг буцсан бололтой.

8. *Калачинов Лиджа Чавочинов*: Монгол улсад хэзээ ирж, хэзээ буцсан нь тодорхойгүй бөгөөд 1924 онд Монгол улсад нүүн ирэх хүсэлт гаргасан халимагуудын бүртгэлийн 67 дугаарт: «... *Калачинов Лиджа Чавочинов эхнэртэй, Платовская өртөөнд амьдардаг, мал сургагч мэргэжилтэй, намын гишүүн бус, монгол ардын цэрэгт хоёр жил алба хаасан*» [МУУТА. ТБА. X. 1. Хн. 29] гэсэн байдаг. Баримтаас тэрээр Монголд хоёр жил цэргийн алба хаасан нь тодорхой бөгөөд харин хэзээ ирж хэзээ буцсан нь тодорхойгүй бөгөөд 1921 онд Монголд ирсэн хоёр хэсэг халимагууд болон 1923 онд монголд байсан халимагуудын бүртгэлд түүний нэр алга байна.

9. *Хахлынов (Хахлынов Данил Бальджирович) нь* 1922 онд Ховдод ажиллаж байсан байсан бөгөөд түүний тухай «...*газар зохион байгуулалтын мэргэжилтэн халимаг Хахлынов Сангийн яаманд хандан газар зохион байгуулах тасаг байгуулах асуудлыг сөхөн тавьж*» байсан тухай мэдээ байдаг. Түүнийг хэзээ Монголд ирж, хэзээ буцсан нь тодорхой биш бөгөөд 1921 оны 6 болон 12 сард Монголд ирсэн дайчдын бүртгэлд түүний нэр байдаггүй. Харин 1924 онд Нийслэл хүрээнд байсан халимаг сурагчдын хамт авахуулсан гэрэл зурагт тэрээр эхнэрийнхээ хамт байдаг. Мөн 1924 оны 12 сарын 10-ны өдөр Х. Б. Кануковын бичсэн «Монгол улсын Ховдын хязгаарт нүүн ирж тохиохыг хүсэх халимаг торгууд нарын нэрсийг тодорхойлон бичсэн хуудас» гэх бүртгэлийн 15 дугаарт «*Хахлынов Данил Бальджирович, 40 настай, Эхнэрийн хамт Монгол улсын Нийслэл хүрээнд суудаг, Газар хэмжиж, зураг үйлдэгч мэргэжилтэй, Бүх Монголын залуучуудын эвлэлийн гишүүн, 1921 оноос эхлэн Монгол газар сууж, Монгол улсын албанд баймой*» [МУУТА. ТБА. X. 1. Хн. 29. Т. 27–32] хэмээн бүтгэсэн байдаг. Эндээс үзэхэд тэрээр 1921 онд ирсэн хоёр бүлэгээс тусдаа мөн онд Монголд ирж, 1925 онд нутаг буцсан бололтой. Тэрээр Монголд байх хугацаандаа зөвхөн цэргийн алба хаагаад зогсохгүй Монголын нам эвлэл, нийгэм аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар санал санаачлага гарган идэвхтэй ажиллаж байжээ.

— *Монголд албан ажлаар ирж байсан халимагууд*

1921 оны хувьсгалын үед цэргийн сургагч нараас гадна албан хэргээр ирж байсан тохиолдол байна. Тухайлбал: Халимагт болсон их өлсгөлөнгийн үед Халимагийн өлсгөлөнд тусламж үзүүлэх төв

комиссоос Оле Лиджиев-Рокчинский, Дандыр Балдушев-Баслиев, Эрдэни Эрендженев нарыг явуулахаар шийдвэрлэсэн [Бадмаева 2010: 175] бөгөөд, тэд 1922 оны 9 дүгээр сарын 28-нд Москвад суугаа Монголын элчин сайдаас 41 тоот бичгээр Монголд очих албан зөвшөөрөл хүссэн ба тус комиссын ахлагч Д. Батушов, 1922 оны 10 дугаар сарын 4-ний өдөр элчин сайд Даваад дахин өргөдөл гаргаж, «Манай Халимагийн автономит мужаас 3 хүн томилогдож, ядарсан Халимагийн ардуудад тусламж эрэхээр Монгол газар одох болсон тул бид нарт Алтан-булагаас Нийслэл Хүрээ хүртэл өртөө улаа...» шийтгүүлэн гаргуулж, 1922 оны 12 сард Монголд иржээ [МУГХТА. X. 2. Д. 1. Хн. 194. Н. 17]. Тэд тусламжийн ажлаа бүтээгээд 1923 оны эхээр нутаг буцсан бололтой. Энэ үед буцах зардал дутагдалтай болсон тул Монголын засгийн газарт хандан замын зардлын тусламж хүсэж байсан баримт байна [МУЗГА. Т. 39].

— *Монголоор дамжин тусгай үүрэг гүйцэтгэж байсан халимагууд*

Халимагууд Монголын ардын армид алба хаахаас гадна ЗОУ-ын тусгай даалгавраар Монгол улсаар дамжин Төвдөд үүрэг гүйцэтгэж байлаа. Одоогоор олдоод байгаа баримт материалаас үзэхэд Зөвлөлт Оросын Улаан армид алба хааж байсан халимагууд Монгол улсаар дамжин Төвдөд хоёр удаа тусгай үүрэг гүйцэтгэсэн байна. Эхний үүргийг 1921 оны 6 сард Монголд ирсэн Халимаг сургагч В. А. Хомутников, Лундуков Шагдар, Дорж Дарминов, Л. Бадминов нар? нарийн халимагууд Буриад лам Яринпилын хамт гүйцэтгэсэн. В. А. Хомутников, Лундуков шагдар, Дорж Дарминов нарын тухай дээр өгүүлсэн.

1. *Л. Бадминовын тухайд* Д. Яримпил, В. А. Хомутников нарын бүлэгт багтсан халимаг хүн хэмээн судлаач А. Басхаев, А. И. Андреев нар тэмдэглэсэн байдаг. Энэхүү бүлэг Нийслэл хүрээнд бүх бэлтгэлээ хангасны дараа дараа хүрээнээс 1921 оны 9 сард гарсан гэдэг. Эндээс үзэхэд тухайн үед Л. Бадминов нь Монгол байсан нь тодорхой.

Монголоор дамжин Төвдөд тусгай үүрэг гүйцэтгэх хоёр дахь хэсэг нь 1926–1928 онд БНМАУ-аас Төвдөд улсад суух элчин сайдын яамны төлөөлөгчид гэх нэрээр явагдсан юм. Энэхүү төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд А. Ч. Чалчаев, М. Т. Бимбаев, Лун-

дуков Шагдар нарын халимагууд оролцсон. М. Т. Бимбаев, Лундуков Шагдар нар бол 1921 оны 6 сард халимаг сургагчдын эхний бүлэгт ирсэн тухай дээр өгүүлсэн.

2. *Араш Чапчаевич Чапчаевын* тухайд Халимагт зөвлөлт засгийг тогтоох үйл хэрэгт идэвхтэй оролцож Зөвлөлт халимагийн удирдагчдын нэг болсон тэрээр энэ ажиллагаанд БНМАУ-аас Төвөдөд улсад суух элчин сайдын зөвлөхөөр Цэвэгдорж гэх нэрээр оролцсон байдаг [Сэсээр 2005: 66] Тэрээр даалгавар гүйцэтгэхийн өмнө Нийслэл хүрээнд ирж бүлгийн үйл ажиллагааг бэлтгэхэд оролцсон бөгөөд даалгавраа гүйцэтгэсний дараа Монголоор дамжин буцсан байдаг.

— *Монголд алба хааж байсан Халимагуудын ар гэр*

Монголд байсан халимагуудын зарим нь гэр бүлийн хамт байсан баримтууд цөөнгүй байна. Эдгээрийг авч үзвэл:

1. *Х. Б. Кануковын гэр бүл*. Ховд сайдын газар ажиллаж байсан Х. Б. Кануков Д. Сүхбаатарт 1922 оны 5 дугаар сарын 9-нд бичсэн захидалдаа Ховдын ерөнхий байдлыг дурдаад дараа нь «... манай эхнэр мөн та хоёрын амрыг эрж байна, хүүхдүүд ч мэнд хүргээрэй гэж гуйцгааж байна» гэх зэргээр бичсэн байдаг [МУУТА. ТБА.Х. 12. Д. 1. Хн. 188]. Эндээс харахад тэрээр Ховдод эхнэр хүүхдийнхээ хамтаар оршин сууж байсан, хүүхдүүдтэй байсан нь мэдэгдэх ба гэр бүлийнхнийхэн нь Д. Сүхбаатарыг сайн мэддэг, харилцан мэнд мэдэлцэх хэмжээний ойр дотно харилцаатай байсан нь харагдана. Х. Б. Кануковын эхнэрийн тухайд Халимагийн үндэсний музейн фондод хадгалагдаж байгаа 1924 онд Нийслэл хүрээнд байсан халимагуудын авахуулсан зураг дээр (зураг № 3) Х. Б. Кануковыг буриад эхнэрийн хамт байгаа гэсэн байдаг.

Харин Халимагийн үндэсний архивд Х. Б. Кануковын 1930-аад оны үед Халимагт эхнэр охины хамт авахуулсан зураг (зураг №1) байдаг. Тус архивд мөн «*нөхөр Х. Б. Кануков Монголын тэргүүн цэргийн гүнгийн хувцастай. Эхнэрийн хамт. Монгол улс. 1922 оны 3-р сарын 8*» гэсэн тайлбартай ёслолын хувцастай авахуулсан зураг [НА РК. Фонд фото] (зураг № 2) байдаг. 1930-аад оны үеийн зураг (зураг № 1) дээрх Х. Б. Кануковын эхнэр гэх хүн 1921 оны зураг дээр мөн байдаг. Эндээс үзэхэд Х. Б. Кануковын орос эхнэр нь 1922 онд мөн Нийслэл хүрээнд байсан болж таарч байна.



Зураг № 1. Х. Б. Кануков гэр бүлийн хамт [НА РК. Фонд фото]



Зураг № 2. «Нөхөр Х. Б. Кануков Монголын тэргүүн цэргийн гүнгийн хувцастай. Эхнэрийн хамт. Монгол улс. 1922 оны 3-р сарын 8» [НА РК. Фонд фото].

2. Хахлыновын гэр бүл

1924 онд Нийслэл хүрээнд ажиллаж амьдарч байсан Халимагууд хамтдаа авхуулсан энэ зураг Халимагийн үндэсний музейн зургийн фондод хадгалагдаж байна.



Зураг № 3. Өргөөд амьдарч байсан Халимагууд.

1924 оны 9 сар [Халимагийн үндэсний музейн фонд].

Арын эгнээнд зогсож байгаа зүүн гар талаас 1. Морхадъяев, дунд эгнээнд сууж байгаа зүүн гар талаас 2. Хахлынов, 3. Эхнэр нь, 4. Кануковын буриад эхнэр, 5. Х. Б. Кануков.

Урд эгнээнд хэвтэж байгаа зүүн гар талаас 1. Н. Б. Кануков, 2. Лиджиев.

Зургийн тайлбараас харахад Хахлынов эхнэрийн хамт Нийслэл хүрээнд байсан нь тодорхой байна.

— Бусад

1922 онд Нийслэлээс хүрээнээс монголын армид алба хааж байсан 20 гаруй сургагчид Ховдод очиход тэнд баян халимаг Доржийнх гэдэг халимаг айл байсан тухай мэдээ бий. «Тэднийх Халимаг нутагтаа хүүхэдгүй байсан бөгөөд нутгийн нэгэн ламаас явал хүүхэдтэй болох тухай асуухад Монгол нутагт очвол хүүхэдтэй

болно гэснээр Ховдын хязгаарт нүүн ирсэн» [Очиров 1970: 31–41] гэдэг. Доржийнх хэзээ хаагуур яаж Монголд хүүж ирсэн, хожим нутаг буцсан, Ховдод суурьшин үлдсэн, үр хүүхэдтэй болсон эсэх нь тодорхойгүй байна. Юутай ч Дорж эхнэрийн хамт хоёулаа амьдарч байсан нь тодорхой байна.

ДҮГНЭЛТ

1921 оны Монголын хувьсгал нь Халимагуудыг угсаа гарал нэгтэй Монголчуудтай ойртон харилцах нэгэн боломжийг олгосон байна. Монгол болон Дорно дахинд явуулах бодлогодоо ЗОУ-ын халимагуудыг тодорхой хэмжээгээр ашиглаж байсан нь энэ харилцаанд бас нөлөөлжээ. Ингэснээр 1920-иод онд Халимагууд Монголд багагүй ирж байжээ. Тэдгээрийг нэр болон тоогоор нь тодруулан авч үзвэл:

- Цэргийн алба хааж байсан халимагууд — 124 хүн,
- Монголд албан ажлаар ирж байсан халимагууд — 3 хүн,
- Монголоор дамжин тусгай үүрэг гүйцэтгэж байсан халимагууд — 2 хүн,
- Монголд алба хааж байсан Халимагуудын ар гэр — 5 хүн
- Бусад — 2 хүн.

Нийтдээ 136 хүн байсныг тодруулж байна. Эдгээр 136 хүний 130 хүнийх нь нэр тодорхой бөгөөд гэр бүлийн эхнэр хүүхэд гэх мэт 6 хүн халимаг байж болох ч нэрийг нь тодруулах баримт алга байна. **Монголд ажиллаж, амьдарч байсан халимагууд** сургуульд суралцах, цэргийн алба халагдах насанд хүрсэн зэрэг шалтгаанаар цэргээс халагдан нутаг буцах, тусгай даалгавар гүйцэтгэхтэй холбоотойгоор Монголд шинэ томилогдон ирэх, Монгол улсаас явах зэргээр тоо бүртгэл нь байгаа өөрчлөгдөж байжээ.

Иймд эдгээр халимагуудын нэр болон тоог тодруулах судалгааг илүү нарийвчлан тодруулах шаардлагатай.

Источники

МУУТА. ТБА — Монгол улсын үндэсний төв архив. Түүхийн баримтын архив.

МУГХТА — Монгол улсын гадаад хэргийн төв архив. Х. 2. Д. 1. Хн. 194.
МУЗГА — Монгол улсын засгийн газрын архив. БНМАУ-ын Засгийн
газрын 1922 оны хурлын тогтоол.
НА РК — Национальный архив Республики Калмыкия

Литература

- Бадмаева 2010 — *Бадмаева Е. Н.* Нижнее Поволжье: Опыт и итоги реализации государственной политики в социально-экономической сфере (1921–1933 гг.). Элиста: ЗАОР «НПП «Джангар», 2010. 544 с.
- Балтыков 1977 — *Балтыков С. Б.* Монголын ардын цэргийн эгнээнд // Ю. О. Оглаев. Интернационалч даалгавартан. Орчуулсан Д. Пунцаг. Улаанбаатар: УХГ, 1977. 136 х.
- Батбаяр 1972 — *Батбаяр Н.* Өндөрт хатгасан туг. Түүхэн найруулал. Улаанбаатар: УХГ, 1972. 195 х.
- Бат-Очир, Отгонжаргал 1996 — *Бат-Очир Л., Отгонжаргал С.* XX зууны монгол дахь улс төрийн түүхэн үйл явц. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 1996. 127 х.
- Внешняя политика 1944 — Внешняя политика СССР 1917–1944 гг. Сборник документов. Т. II (1921–1924 гг.) / сост. А. С. Тисминец, отв. ред. С. А. Лозовский, ред. и прим. Б. Е. Штейн. М.: [б. и.], 1944. 979 с.
- Даш 1967 — *Даш Д.* Монгол түмний төлөө зүтгэсэн анд нөхөд. Ред. Л. Санжаа. Улаанбаатар: УХГ, 1967. 142 х.
- Д. Сүхбаатарын тухай баримт 1960 — Д. Сүхбаатарын тухай баримт материалын эмхэтгэл. Улаанбаатар: УХГ, 1960. 157 х.
- Монгол ардын журамт 1982а — Монгол ардын журамт цэргийн дургалууд. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар: УХГ, 1982. 712 х.
- Монгол ардын журамт 1982б — Монгол ардын журамт цэргийн дургалууд. Дэд дэвтэр. Улаанбаатар: УХГ, 1982. 895 х.
- Номинханов 1977 — *Номинханов Ц.-Д.* Нэгэн жагсаалд // Ю. О. Оглаев. Интернационалч даалгавартан. Орчуулсан Д. Пунцаг. Улаанбаатар: УХГ, 1977. 136 х.
- Оглаев 1977 — *Оглаев Ю. О.* Интернационалч даалгавартан / ред. И. Златкин. Орчуулсан Д. Пунцаг, Ж. Гомбосүрэн. Улаанбаатар: УХГ, 1977. 136 х.
- Очиров 1970 — *Очиров Ц.-М.* Два года в Монголии // Ю. О. Оглаев. С Интернациональной миссией. Элиста: Калм. кн. изд-во, 1970. 143 с.
- Советско-монгольские отношения 1966 — Советско-монгольские отношения. 1921–1966: сб. док. / сост.: М. И. Гольман, Г. И. Слесарчук. М.: Наука, 1966. 360 с.

- Сүхбаатар 2000 — *Сүхбаатар На.* Баруун хязгаарын нийгэм-улс төрийн хөгжлийн түүхэн тойм (XX зууны эхэн үеэс 1930-аад он). Ред. Ж. Болдбаатар. Улаанбаатар: Соёмбо ХХК, 2000. 113 х.
- Сэсээр 2005 — *Сэсээр 3.* Хичээнгүй баатар Гомбо-Идшин гүн. Улаанбаатар: Алтан үсэг үйлдвэр, 2005. 248 х.
- Шапшуков 1977 — *Шапшуков Г. А.* Монгол ард улсад байсан таван жилээ дурсан санахад // Ю. О. Оглаев. Интернационалч даалгавартан. Орчуулсан Д. Пунцаг. Улаанбаатар: УХГ, 1977. 136 х.